



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 505

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн дуудлагын худалдааг  
дахин зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 81,196,100.00 (наян нэгэн сая нэг зуун ерэн зургаан мянга нэг зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашины 3 дахь дуудлагын худалдааг дахин зохион байгуулсугай.

2. Автомашины худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

3. Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны дарга С.Чинзоригт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

3.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу байгууллагын дансанд төвлөрүүлэх;

3.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б. ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 10 дугаар сарын ...-ны өдрийн  
.....дугаар тогтоолын хавсралт



**Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, дахин нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	ТӨБЗГ-ын 2018 оны 350 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Худалдах доод үнэ шинэчлэн тогтоосон
1	УАЗ-3909 маркийн, 12-10 УНП улсын дугаартай, Арлын дугаар - 37410040413002	2004/2004	407941	11,800,000.00	1,500,000.00	1,000,000.00
2	УАЗ-2206 маркийн, 52-00 БӨА улсын дугаартай, Арлын дугаар - 000100630472666	2003/2003	296052	11,573,200.00	1,500,000.00	1,000,000.00
3	УАЗ-2206 маркийн, 47-25 ЗАА улсын дугаартай, Арлын дугаар - 30472048	2003/2003	231010	11,573,200.00	1,500,000.00	1,000,000.00
4	УАЗ-3909 маркийн, 74-59 СУА улсын дугаартай, Арлын дугаар - ХОО331906	2001/2001	115076	8,025,000.00	1,500,000.00	1,000,000.00
5	Ssangyong Rexton маркийн, 48-92 УБК улсын дугаартай, Арлын дугаар - КРВFA2AF14P1268	2004/2005	333027	18,698,700.00	2,000,000.00	1,500,000.00
6	УАЗ-31514 маркийн, 62-85 УБУ улсын дугаартай, Арлын дугаар - 0018098	1999/1999	446142	7,026,000.00	1,500,000.00	1,000,000.00
7	УАЗ-2206 маркийн, 68-96 ЗАН улсын дугаартай, Арлын дугаар -604866538	2006/2006	534314	12,500,000.00	1,500,000.00	1,000,000.00
				81,196,100.00	11,000,000.00	7,500,000.00
	Нийт дүн			81,196,100.00 (наян нэгэн сая нэг зуун ерэн зургаан мянга нэг зуун)	11,000,000.00 (арван нэгэн сая)	7,500,000.00 (долоон сая таван зуун мянган)